



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Номин Карт ББСБ” ХХК-ийн захирал танаа

Дүгнэлт

Бид “Номин Карт ББСБ” ХХК (Цаашид “Компани” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Номин Карт ББСБ” ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж, гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторовн тайланг багтаахгүй.

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдийн үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй. Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлээгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.



Г.ДЭЛГЭРЦЭЦЭГ
ЗАХИРАЛ АУДИТОР

Монгол улс, улаанбаатар хот
2021 оны 02 дугаар сарын 25

"НОМИН КАРТ" ББСБ ХХК
 АУДИТЛАГДСАН БАЛАНС
 2020 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
 ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

	Тодруулга	2020.12.31	2019.12.31
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3	2,056,722,158	285,559,179
Богино хугацаат хөрөнгө оруулалт		33,861,920	33,861,920
Нийт зээл	4	3,936,519,588	5,210,275,370
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		145,436,870	98,639,760
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	5	1,030,554	3,078,270
Бусад авлага		36,570,683	149,885,257
Бараа материал		90,200	866,324
Эргэлтийн хөрөнгийн дүн		6,210,231,973	5,782,166,080
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн			
Нийт хөрөнгийн дүн		6,210,231,973	5,782,166,080
Өр ба эзний өмч			
Богино хугацаатай өр			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл			
Өрийн бичгээрх өглөг		1,200,000,000	1,310,000,000
Цалингийн өглөг		4,567,607	3,694,287
Татварын өглөг		17,917,420	20,544,309
Хүүгийн өглөг		116,427,041	64,443,288
Бусад богино хугацаат өр төлбөр		4,712,645	6,165,569
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,343,624,712	1,404,847,452
Урт хугацаат өр			
Урт хугацаат өр төлбөрийн дүн			
Нийт өр төлбөрийн дүн		1,343,624,712	1,404,847,452
Эзний өмч			
Энгийн хувьцаа	1	2,500,000,000	2,500,000,000
Хуримтлагдсан ашиг алдагдал		2,366,607,261	1,877,318,628
Эзний өмчийн дүн		4,866,607,261	4,377,318,628
Нийт өр төлбөр ба эзний өмчийн дүн		6,210,231,973	5,782,166,080

"НОМИН КАРТ" ББСБ ХХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

	Тодруулга	12/31/2020	2019.12.31
Хүүгийн орлого	6	1,165,362,756	1,047,232,961
Хүүгийн зардал	7	(193,217,575)	(222,961,670)
Цэвэр хүүгийн орлого		972,145,181	824,271,291
Хүүгийн бус орлого	8	125,398,284	473,584,839
Хүүгийн бус зардал	9	(429,863,252)	(466,653,757)
Цэвэр хүүгийн бус орлого		(304,464,968)	6,931,081
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг		667,680,213	831,202,372
Болзошгүй эрсдэлийн зардал		(127,667,401)	
Үндсэн үйл ажиллагааны ашиг		540,012,812	831,202,372
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал		12,355	(479,157)
Татвар төлөхийн өмнөх ашиг		540,025,167	830,723,215
Орлогын татварын зардал		50,736,535	83,063,164
Татвар төлсний дараах ашиг		489,288,633	747,660,052

"НОМИН КАРТ" ББСБ ХХК
 АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2020 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
 ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Бүгд
2019 оны 12 сарын 31 ны өдөр	2,500,000,000	1,877,318,628	4,377,318,628
Тайлан үеийн цэвэр ашиг алдагдал		489,288,633	489,288,633
2020 оны 12 сарын 31 ны өдөр	2,500,000,000	2,366,607,261	4,866,607,261